

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан,
түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

**Компанийн 2016 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус
аудитын дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн Дүрмийн 7.8.7 дахь заалт 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай:
 - 1.1. Нийт хөрөнгийг **39,000,359,074** (гучин есөн тэрбум гурван зуун тавин есөн мянга далан дөрөв) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 18,344,099,700 (арван найман тэрбум гурван зуун дөчин дөрвөн сая ерэн есөн мянга долоон зуу) төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг **20,656,259,374** (хорин тэрбум зургаан зуун тавин зургаан сая хоёр зуун тавин есөн мянга гурван зуун далан дөрөв) төгрөгөөр
 - 1.2. Өр төлбөрийн нийт дүнг **8,635,063,743** (найман тэрбум зургаан зуун гучин таван сая жаран гурван мянга долоон зуун дөчин гурав) төгрөгөөр
 - 1.3. Эзэмшигчийн өмчийг **30,365,295,330** (гучин тэрбум гурван зуун жаран таван сая хоёр зуун ерэн таван мянга гурван зуун гуч) төгрөгөөр тус тус баталсугай.
2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА **Ч.ПҮРЭВСҮРЭН**



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

**Компанийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт, Аудитын
хорооны дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлт, Аудитын хорооны дүгнэлтийг тус тус баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд олонхийн санал авсан:

- Ердийн гишүүдэд:

- Г.Эрдэнэбулган
- О.Хуягцогт
- Ц.Баяр-Эрдэнэ
- Жу Хён Мин

- Хараат бус гишүүдэд:

- Кан Ён Мин
- Ж.Тамир
- Л.Болормаа

нарыг 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр тус тус сонгосугай.

2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 42 тоот тогтоолыг үндэслэн Д.Эрэвгийлхам, Ж.Ганбат, Б.Төмөрхүү нарыг, КТ корпорацийн санал болгосноор Рью Гил Хёныг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас, С.Эркебулан, Ц.Мөнх-Эрдэнэ нарыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.
3. Компанийн үр ашигтай үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Ч.ПҮРЭВСҮРЭН



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны
зардлын төсөв батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг Хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалин хөлсийг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Жу Хён Мин)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ПҮРЭВСҮРЭН



Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын № 05 тоот тогтоолын Хавсралт-1



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсөв

	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
1. Цалин, холбоо, тээврийн зардал					
1	ТУЗ-ийн гишүүд	9.0	350,000	12	37,800,000
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1.0	280,000	12	3,360,000
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1.0	150,000	12	1,800,000
	Цалин, холбоо, тээврийн зардлын дүн				42,960,000
2. Бичиг хэрэг ба ёслол					
1	Бичиг хэргийн материал		70,500	12	846,000
2	Байрны түрээс		235,000	12	2,820,000
3	Хэвлэл		500,000	1	500,000
4	Ёслол ба бусад		117,500	12	1,410,000
	Бичиг хэрэг ба ёслолын зардлын дүн				5,576,000
3. ТУЗ-ийн хурлыг БНСУ-д эсхүл Монгол Улсад зохион байгуулах					
1	Тээврийн зардал	7.0	2,600,000	1	18,200,000
2	Байрны хөлс (5 өдөр)	7.0	500,000	5	17,500,000
3	Визийн хураамж	7.0	50,000	1	350,000
4	Томилолт (5 өдөр)	7.0	125,000	5	4,375,000
	ТУЗ-ийн хурлыг БНСУ-д эсхүл Монгол Улсад зохион байгуулах зардлын дүн				40,425,000
	Нийт дүн				88,961,000